



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудит
Аудитын код: БНА-2019/54/СТА-ТШЗ



Баянхонгор
2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор: Ж.Өсөхбаяр

Утас: 99890393 Цахим хаяг: usukhbayar_j@yahoo.com

Цахим хуудас: www.audit.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	11
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.02.25 № 12/76

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

ЭРДЭНЭЦОГТ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ш.ГЭРЭЛМАА ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод

E:\Usukhuu\STA-2019\10.Эрдэнэцогт сургууль\4.Тайлагнал\Эрдэнэцогт ЕБС_гэрчилгээ.docx

2519134

хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem.

Б.МӨНХБАТ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Сургуулийн захирал Ш.Гэрэлмаа-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар 25-наас 2019 оны 02 дугаар 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургууль нь “Сурагчдыг бие даасан бүтээлчээр сурах, хөгжих, хүмүүжих сургалтын таатай орчинг бүрдүүлэн тэднийг ёс суртахууны боловсролд суурилсан харилцааны соёлтой, хариуцлагатай, мэргэжлийн чиг баримжаатай хүүхэд болгон төлөвшүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Суралцагч бүрийн сурлагын чанарт ахиц гаргах

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 736067.4 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 14721.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэв.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	374.7	
	Дүн	1	374.7	

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 682068,6 мянган төгрөгийн БНА-2019/54/СТА-ТШЗ

төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 681504.5 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь 2018 онд 681568.6 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулан 64.0 мянган төгрөг хэмнэгдсэнтэй холбоотой байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Тус байгууллага нь Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит”-аар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 25 мэдээллийг хугацаанд нь, 6.4-д заасан мэдээллээс өөрт хамаарах 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 18 гүйлгээг хугацаанд нь тус тус мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

3.1.1 Илрүүлэлт:

2018 оны 12 дугаар сард ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 374.7 мянган төгрөгийг хоол хүнсний зардлаас төсвийн зохицуулалт хийлгүйгээр зарцуулсан нь “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төвийн тухай хуулийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Төсвийн зардлын бүлэг хооронд зөвшөөрөлгүй шилжүүлэн зарцуулсан

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулж, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ыг хэрэгжүүлж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвшөөрсөн, хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 04 дүгээр сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	78,193,593.54	82,994,175.34
33	АВЛАГА	1,686,576.00	1,305,477.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,686,576.00	1,305,477.00
35	БАРАА МАТЕРИАЛ	76,507,017.54	81,688,698.34
351	Түүхий эд материал	1,868,400.00	2,021,600.00
35110	Тусгай зориулалттай материал	1,868,400.00	1,868,400.00
35130	Эм боох материал	00.00	153,200.00
354	Хангамжийн материал	74,638,617.54	79,667,098.34
35410	Бичиг хэргийн материал	840,640.00	1,279,300.00
35420	Аж ахуйн материал	69,745,687.54	73,307,938.34
35460	Хүнсний материал	2,057,440.00	3,457,360.00
35470	Бусад хангамжийн материал	1,994,850.00	1,622,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,078,745,676.40	1,684,626,362.07
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,078,745,676.40	1,684,626,362.07
392	Биет хөрөнгө	1,078,382,343.48	1,642,911,529.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,239,295,991.00	1,552,461,640.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-303,046,050.87	-34,277,939.16
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	177,815,708.26	177,815,708.26
39206	Хуримтлагдсан элэгдэл	-94,788,007.38	-116,384,830.98
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	77,247,640.96	87,665,640.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	-38,958,793.42	-45,184,544.84
39217	Ном	20,815,854.93	20,815,854.93
393	Биет бус хөрөнгө	363,332.92	41,714,832.90
39301	Програм хангамж	1,130,000.00	1,130,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-766,667.08	-841,167.10
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	41,426,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,156,939,269.94	1,767,620,537.41
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	286,566.00	1,232,215.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	286,566.00	1,232,215.00
413	Өглөг	286,566.00	1,232,215.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	286,566.00	1,232,215.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,156,652,703.94	1,766,388,322.41
51	Засгийн газрын хувь оролцоо	1,156,652,703.94	1,766,388,322.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	323,398,419.85	323,398,419.85
51101	Өмч: - төрийн	323,398,419.85	323,398,419.85
512	Хуримтлагдсан үр дүн	716,463,051.94	725,224,586.14
51210	Өмнөх үеийн үр дүн	716,463,051.94	716,463,051.94
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	8,761,534.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	116,791,232.15	717,765,316.42
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,156,939,269.94	1,767,620,537.41

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	947,730,276.00	744,828,943.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,094,200.00	51,485,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,094,200.00	51,485,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,094,200.00	51,485,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	485,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,609,200.00	51,485,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	237,063,176.00	11,775,343.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	211,507,107.00	00.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	211,507,107.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	699,572,900.00	681,568,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,024,779.00	11,089,286.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,024,779.00	11,089,286.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	17,531,290.00	686,057.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	17,531,290.00	686,057.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	754,123,400.06	736,067,408.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	754,123,400.06	736,067,408.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	638,086,127.06	673,827,326.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	374,678,847.00	397,976,123.00
210101	Үндсэн цалин	374,678,847.00	397,976,123.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,700,152.00	48,006,708.00
210201	Тэтгэврийн даатгал	41,700,152.00	48,006,708.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	125,377,530.00	128,036,911.00
210301	Гэрэл, цахилгаан	5,787,248.00	5,866,384.00
210302	Тулш, халаалт	119,399,282.00	122,170,527.00
210303	Цэвэр, бохир ус	191,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,415,524.00	3,840,896.20
210401	Бичиг хэрэг	3,468,880.00	1,496,630.00
210402	Тээвэр, шатахуун	1,190,060.00	1,073,470.00
210403	Шуудан, холбоо, интэрнэгийн төлбөр	699,084.00	104,697.00
210404	Ном, хэвлэл	00.00	84,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,057,500.00	1,082,099.20
2105	Нормативт зардал	31,070,890.00	37,648,790.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	301,600.00	33,100.00
210502	Хоол, хүнс	30,148,290.00	37,277,010.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	621,000.00	338,680.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,812,600.00	1,530,000.00
210604	Урсгал засвар	5,812,600.00	1,530,000.00
2107	Томилолт, зочны зардал	588,000.00	416,300.00
210702	Дотоод албан томилолт	588,000.00	416,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	913,696.00	2,414,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	913,696.00	2,414,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,528,888.06	53,957,398.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,427,163.00	3,992,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	820,000.00	3,028,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,281,725.06	46,937,398.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	116,037,273.00	62,240,082.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	115,010,859.00	62,175,995.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	17,531,290.00	686,057.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,704,495.00	9,073,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	43,775,924.00	21,276,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	20,610,150.00	30,896,338.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,389,000.00	244,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,026,414.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,026,414.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	64,087.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	64,087.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	193,606,875.94	8,761,534.20
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	193,606,875.94	8,761,534.20

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	725,613,969.00	693,343,943.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	485,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	485,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	485,000.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	485,000.00	00.00
13	ГУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	725,128,969.00	693,343,943.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	699,572,900.00	681,568,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,024,779.00	11,089,286.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,024,779.00	11,089,286.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	17,531,290.00	686,057.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	17,531,290.00	686,057.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	725,613,969.00	693,343,943.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	725,613,969.00	693,343,943.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	607,192,666.00	622,713,871.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	377,184,027.00	393,442,535.00
210101	Үндсэн цалин	298,199,360.00	333,824,874.00
210102	Нэмэгдэл	61,772,326.00	46,853,900.00
210104	Урамшуулал	17,212,341.00	12,763,761.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,662,196.00	47,605,862.00
210201	Тэтгэврийн даатгал	40,662,196.00	32,865,545.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	3,694,733.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	2,924,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	742,297.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	7,378,987.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	126,487,468.00	128,036,911.00
210301	Гэрэл, цахилгаан	5,437,986.00	5,738,000.00
210302	Түлш, халаалт	120,858,482.00	122,170,527.00
210303	Цэвэр, бохир ус	191,000.00	128,384.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,669,944.00	6,766,157.00
210401	Бичиг хэрэг	749,650.00	636,240.00
210402	Тээвэр, шатахуун	1,080,860.00	1,073,470.00
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	1,098,284.00	277,947.00
210404	Ном, хэвлэл	292,800.00	501,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,448,350.00	4,277,200.00
2105	Нормативт зардал	35,569,990.00	30,652,120.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	301,600.00	186,300.00
210502	Хоол, хүнс	29,341,890.00	29,870,590.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,926,500.00	595,230.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,074,442.00	1,671,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,700,000.00	00.00
210604	Урсгал засвар	3,374,442.00	1,671,700.00
2107	Томилолт, зочны зардал	588,000.00	298,300.00
210702	Догоод албан томилолт	588,000.00	298,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,568,996.00	6,289,586.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,568,996.00	6,289,586.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,387,603.00	7,950,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,987,603.00	2,218,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	5,731,800.00

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	118,421,303.00	70,630,072.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	117,394,889.00	70,565,985.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	17,531,290.00	686,057.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,088,525.00	17,507,190.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	43,775,924.00	21,276,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	20,610,150.00	30,896,338.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,389,000.00	200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,026,414.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,026,414.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	64,087.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	64,087.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	323,398,419.85	116,791,232.15	716,463,051.94	1,156,652,703.94
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	323,398,419.85	116,791,232.15	716,463,051.94	1,156,652,703.94
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	323,398,419.85	116,791,232.15	716,463,051.94	1,156,652,703.94
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	600,974,084.27	00.00	600,974,084.27
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	8,761,534.20	8,761,534.20
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	323,398,419.85	717,765,316.42	725,224,586.14	1,766,388,322.41

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	544,895,300.00	540,810,456.04	682,068,600.00	681,504,513.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	544,895,300.00	540,810,456.04	682,068,600.00	681,504,513.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	513,327,600.00	508,818,789.54	612,187,800.00	611,624,585.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	370,193,900.00	367,544,921.00	388,912,000.00	388,359,135.00
210101	Үндсэн цалин	269,714,900.00	323,323,509.00	311,734,200.00	328,741,474.00
210102	Нэмэгдэл	70,051,600.00	40,615,649.00	61,784,400.00	46,853,900.00
210104	Урамшуулал	30,058,500.00	3,605,763.00	15,393,400.00	12,763,761.00
210105	Гэрээг ажлын хөлс	368,900.00	00.00	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,721,400.00	41,255,635.55	47,231,900.00	47,605,862.00
210201	Тэтгэврийн даатгал	40,721,400.00	41,255,635.55	47,231,900.00	32,865,545.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	00.00	3,694,733.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	00.00	2,924,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	00.00	742,297.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	00.00	7,378,987.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,428,400.00	66,241,964.00	128,037,000.00	128,036,911.00
210301	Гэрэл, цахилгаан	3,201,000.00	4,158,809.00	5,738,000.00	5,738,000.00
210302	Түлш, халаалт	65,662,000.00	61,961,655.00	122,299,000.00	122,170,527.00
210303	Цэвэр, бохир ус	565,400.00	121,500.00	00.00	128,384.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,758,500.00	4,390,949.00	6,773,700.00	6,766,157.00
210401	Бичиг хэрэг	487,700.00	1,083,875.00	636,300.00	636,240.00
210402	Тээвэр, шатахуун	731,600.00	2,633,918.00	1,081,000.00	1,073,470.00
210403	Шуудан, холбоо, интэрнэгийн төлбөр	1,021,800.00	33,871.00	277,900.00	277,947.00
210404	Ном, хэвлэл	643,700.00	266,400.00	501,300.00	501,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	873,700.00	372,885.00	4,277,200.00	4,277,200.00
2105	Нормативт зардал	23,512,800.00	23,879,140.00	31,027,000.00	30,652,120.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	147,400.00	112,600.00	186,400.00	186,300.00
210502	Хоол, хунс	22,566,600.00	22,560,600.00	30,245,400.00	29,870,590.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	798,800.00	1,205,940.00	595,200.00	595,230.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	955,800.00	849,200.00	1,671,700.00	1,671,700.00
210604	Урсгал засвар	955,800.00	849,200.00	1,671,700.00	1,671,700.00
2107	Томилот, зочны зардал	492,200.00	390,300.00	298,300.00	298,300.00
210702	Дотоод албан томилолт	492,200.00	390,300.00	298,300.00	298,300.00

Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	461,100.00	353,699.99	283,700.00	283,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	461,100.00	353,699.99	283,700.00	283,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3803500.00	3912980.00	7952500.00	7950700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,803,500.00	3,912,980.00	2,218,900.00	2,218,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00	5,733,600.00	5,731,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31567700.00	31991666.50	69880800.00	69879928.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,567,700.00	31,991,666.50	69,880,800.00	69,879,928.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,008,300.00	15,622,090.50	17,508,000.00	17,507,190.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	00.00	21,276,400.00	21,276,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,559,400.00	16,369,576.00	30,896,400.00	30,896,338.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	00.00	200,000.00	200,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	544,895,300.00	540,456,756.04	682,068,600.00	681,504,513.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	544,595,300.00	540,103,056.04	681,568,600.00	681,504,513.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	544,595,300.00	540,103,056.04	00.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	00.00	681,568,600.00	681,504,513.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	300,000.00	353,700.00	500,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	353,700.00	500,000.00	00.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	01.00	01.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	01.00	01.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	48.00	47.00	48.00	47.00
620001	Удирдах ажилтан	03.00	03.00	03.00	03.00
620002	Гүйцэтгэх ажилтан	28.00	27.00	28.00	27.00
620003	Үйлчлэх ажилтан	17.00	17.00	17.00	17.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	420.00	398.00	416.00	402.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	420.00	398.00	416.00	402.00
630001	Төрийн өмчит ЕБС	420.00	398.00	416.00	402.00